



МОНГОЛ УЛСЫН
ДЭЭД ШҮҮХ

2023

Мэдээллийн ил тод байдал



Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол



Монгол Улсын дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоол



Шүүхийн шийдвэрийн тойм



Шүүх хуралдааны зар, тойм

Холбоо барих:

Хаяг: Монгол Улсын дээд шүүх, Ж.Самбуугийн гудамж 18, 4-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170

Утас: 261544

Facebook: @Монгол Улсын дээд шүүх

Twitter: @SupremeCourtMN

info@supremecourt.mn



БАНЗУУЛАГЫН
ОРКОЛ



Манай мөнгө хуужаар
ашиглана уу.



Гарчиг

Ерөнхий шүүгчийн зурвас	3
Улсын дээд шүүхийн шүүгчид	5
Улсын дээд шүүхийн шүүн таслах ажиллагаа	7
Танхимын нийт шүүгчийн хуралдаан	8
Хяналтын шатны шүүх хуралдаан	10
Бусад шүүх хуралдаан	11
Шүүн таслах ажиллагааны хугацаа	12
Улсын дээд шүүхийн онцлох шийдвэрүүд	13
Нийт шүүгчийн хуралдаан, Шүүгчдийн зөвлөгөөн	14
Олон улсын хамтын ажиллагаа	16
Нээлттэй шүүх	21
Номын сан, шүүгчдийн бүтээл	24
Нийт шүүгчийн чуулган 2023	25
Улсын дээд шүүхийн Тамгын газар	27
Иргэдийн боловсролд	29



Ерөнхий шүүгчийн зурвас

Та бүхэнтэй Монгол Улсын дээд шүүхийн 2023 оны тайлан – танилцуулгаар мэндчилж буйдаа баяртай байна. Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр үйлчилж эхлээд гурав дахь жилээ үдэж буй өнгөрөгч он бидний хувьд шүүхийн шинэчлэлийг эргэн харж дүгнэсэн, эрчимжүүлсэн жил байлаа.

Энэ хугацаанд Монгол Улсын дээд шүүх шүүхийн сахилга хариуцлага, ил тод, бие даасан байдлыг дээшлүүлэх гурван тулгуурт бодлогыг баримталж шүүхийг цахимжуулах, шүүх эрх мэдлийн зохион байгуулалтын талаарх хууль тогтоомжийг сайжруулж иргэдийн шүүхээр хамгаалуулах эрхийг баталгаатай эдлүүлэх, шүүгчдийн ойлголцлыг нэмэгдүүлж хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, Монгол Улсын шүүхийн байгууллагын гадаад улс дахь нэр хүндийг өсгөх чиглэлээр тухайлан анхаарч ажиллаа.

Нийгмийн хөгжлийн үндсэн тулгуур болох шударга ёсыг өргөн сахигч шүүхийн байгууллага нээлттэй, ил тод байх нь нийгэмдээ эл шударга ёсыг түгээн дэлгэрүүлэх чухал арга зам болдог. Энэ ч үүднээс бид бүхэн хяналтын шатны шүүхийн үйл ажиллагааны мэдээ, шийдвэрийн тойм, хураангуйг тогтмол нийтлэхээс гадна шүүхийн боловсролыг дэмжих хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж байна.

Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах хүрээнд Улсын дээд шүүх шүүн таслах бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс гадна Нийт шүүгчийн хуралдаанаараа хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны 9 тайлбар гаргажээ. Мөн хуулийн төсөлд санал өгөх асуудлыг 11 удаа хэлэлцэж холбогдох саналыг хүргүүлээ. Үүнд, салбарын хөгжилд чухал нөлөөтэй процессын хуулиуд, шүүх байгуулах тухай, Улсын дээд шүүхэд бүртгэгдэх байгууллагын эрх зүйн байдалтай холбоотой болон бусад материаллаг хуулийн төслүүд хамаарч байна.

Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн шүүгчийг мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулахын сацуу шаардлагатай судалгаа, мэдээллээр хангаж, судлаач шүүгчдийг хуульд заасан журмын дагуу эрдэм шинжилгээний ажил эрхлэх нөхцөлийг бүрдүүлснээр нэг талаас шүүгчийг чадавхжуулж, нөгөө талаас шүүгчдийн мэдлэгийг шинжлэх ухааны эргэлтэд оруулж эхлэв.

Шүүхийн гадаад харилцааны хувьд 2023 онд олон улсын хэд хэдэн төсөл, хөтөлбөрийг шүүх эрх мэдлийн хүрээнд нэвтрүүлэх ажил хэрэгжиж эхэлсэн төдийгүй Улсын дээд шүүхийн шүүгч Олон улсын эрүүгийн шүүхийн шүүгчээр томилогдсон нь Монголын шүүгчдийн мэдлэг, чадварыг олон улсын тавцанд баталсан явдал боллоо.

Цаашид шүүх эрх мэдлийг хөгжүүлэхэд Улсын дээд шүүх улам манлайлж зүтгэх томоохон ажлууд эрчимтэй өрнөж байна. Уншигч та энэхүү эмхэтгэлээс бидний 2023 онд хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн тоймтой танилцах боломжтой бөгөөд цаашид Улсын дээд шүүхийн үйл ажиллагаатай цахимаар болон биечлэн танилцах бол бидний үүд хаалга үргэлж нээлттэйг дахин дурдъя.



Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч
ДАМДИНЫ ГАНЗОРИГ

Улсын дээд шүүхийн бүрэлдэхүүн



- Хууль зүйн дээд боловсролтой
- Мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан
- 35 нас хүрсэн

Монгол Улсын иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр томилно.



Улсын дээд шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс **Улсын Их Хуралд** танилцуулснаар **Монгол Улсын Ерөнхийлөгч** томилно.



Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос **зургаан жилийн хугацаагаар** Монгол Улсын Ерөнхийлөгч томилно.

Улсын дээд шүүхийн шүүгчид

Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн
Чагдаагийн Хосбаяр
2015 оноос УДШ-н шүүгч, 2021 оноос
Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн

Шүүгч Содномдаржаагийн Батдэлгэр
2010 оноос

Шүүгч Дамдины Эрдэнэбалсүрэн
2012 оноос

Шүүгч Батаагийн Батцэрэн
2013 оноос

Шүүгч Баттогоогийн Цогт
2013 оноос

Шүүгч Болдын Амарбаясгалан
2019 оноос

Шүүгч Сосорбурамын Соёмбо-Эрдэнэ
2021 оноос

Шүүгч Мөнхөөгийн Пүрэвсүрэн
2022 оноос

Иргэний хэргийн танхимын тэргүүн
Гүррагчаагийн Алтанчимэг
2015 оноос УДШ-н шүүгч, 2021 оноос
Иргэний хэргийн танхимын тэргүүн

Шүүгч Хуушааны Эрдэнэсүвд
2013 оноос

Шүүгч Дашхүүгийн Цолмон
2013 оноос

Шүүгч Пунцагийн Золзаяа
2015 оноос

Шүүгч Нямдоогийн Баярмаа
2022 оноос

Шүүгч Нэргүйн Батчимэг
2023 оноос

Шүүгч Намсрайн Батзориг
2023 оноос

Захиргааны хэргийн танхимын тэргүүн
Дашдоржийн Мөнхтуяа
2013 оноос УДШ-н шүүгч, 2022 оноос
Захиргааны хэргийн танхимын тэргүүн

Шүүгч Хөхийсүрэнгийн Батсүрэн
2012 оноос

Шүүгч Мишигийн Батсуурь
2013 оноос

Шүүгч Пүрэвдоржийн Соёл-Эрдэнэ
2015 оноос

Шүүгч Гочоогийн Банзрагч
2016 оноос

Шүүгч Цэндийн Цогт
2020 оноос

Шүүгч Дэмбэрэлийн Батбаатар
2022 оноос



2023 онд өндөр насны тэтгэвэрт гарсан болон шинээр томилогдсон шүүгчид



Шүүгч Б.Мөнхтуяа
2023 онд өндөр насны
тэтгэвэрт гарав



Шүүгч Намсрайн Батзориг
2023 оны 10 дугаар сарын 17-ны
өдрөөс Улсын дээд шүүхийн
шүүгчээр томилогдон ажиллаж
байна.



Шүүгч Нэргүйн Батчимэг
2023 оны 10 дугаар сарын 17-ны
өдрөөс Улсын дээд шүүхийн
шүүгчээр томилогдон ажиллаж
байна.




Улсын дээд шүүхийн шүүн таслах ажиллагаа



Хяналтын журмаар гаргасан гомдлыг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх танхимын нийт шүүгчийн хуралдаан



Хяналтын шатны шүүх хуралдаан




Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаан



Улсын дээд шүүхийн тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах тухай хүсэлт хэлэлцэх хуралдаан



Хяналтын шатны сахилгын хэргийн шүүх хуралдаан




Танхимын нийт шүүгчийн хуралдаан

Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч гомдол гаргасан хэрэг бүрийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцдэггүй. Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар гомдлыг хэлэлцэх бөгөөд


- ▶ Шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах
- ▶ Хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн
- ▶ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн
- ▶ Эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой

аль нэг үндэслэлээр хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж **4, түүнээс дээш** шүүгч санал нэгдвэл хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэнэ.

2023 онд Улсын дээд шүүхийн Танхимын **нийт шүүгчийн хуралдаанаар** хэлэлцүүлсэн гомдол



2023 онд Улсын дээд шүүхийн Танхимын **нийт шүүгчийн хуралдаанаас хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр** шийдвэрлэсэн



Иргэний хэрэг гэдэг нь иргэд, хуулийн этгээд хооронд үүссэн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус маргаан бөгөөд уг маргааныг иргэний хэргийн шүүх шийдвэрлэнэ.

Захиргааны хэрэг гэдэг нь нэг талаас иргэн, хуулийн этгээд, нөгөө талаас төрийн захиргааны байгууллагын хооронд үүссэн маргаан бөгөөд үүнийг захиргааны хэргийн шүүх шийдвэрлэдэг.

Эрүүгийн хэрэг гэдэг нь Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай гэмт үйлдэл бөгөөд эрүүгийн хэргийн шүүх нь хэрэгт холбогдогч, шүүгчдэгч гэмт хэрэг үйлдсэн эсэх, хэрэв тийм бол ямар хариуцлага хүлээлгэхийг шийдвэрлэдэг.

Хяналтын журмаар гаргасан гомдлыг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж хүлээж авах эсэхийг шийдвэрлэх (21 хоног)

Хийгдэх ажиллагаа	Хариуцах ажилтан	Явц өдрөөр
Хэргийг бүртгэж хүлээн авна.	Бүртгэгч	1
Шүүгчийн туслахад хүлээлгэн өгнө.	Ахлах референт	
Шийдвэр, магадлал, хяналтын гомдол, хариу тайлбарыг бэлтгэн танхимын нийт шүүгчдэд тараана.	Хариуцсан шүүгчийн туслах	2
“Хяналтын хуудас” бэлдэж, танхимын тэргүүнд танилцуулна.	Хариуцсан шүүгчийн туслах	2-3
Төсөөтэй хэргийн судалгааг бэлтгэн хуралдаанаас өмнө шүүгч нарт тараана.	Судлаач туслах	3-5
Хуралдааны өмнө зарыг, дуусмагц тоймыг гаргана.	Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга	6-7
Гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзсан бол тогтоолыг хэрэгт хавсаргаж, хувийг гомдол гаргагчид гардуулж өгнө.	Ахлах референт	14
Хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэвэл системд оруулан хуваарилна.	Ахлах референт	
Шаардлагатай гэж үзвэл хэлэлцэхийг түр хойшлуулж холбогдох нэмэлт судалгааг хийж шүүгчдэд танилцуулна.	Судлаач туслах	
Тогтоолын төслийг бэлтгэж, системд байршуулна.	Хариуцсан шүүгчийн туслах	


Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэрэг хянан шийдвэрлэх (30 хоног)

Хийгдэх ажиллагаа	Хариуцах ажилтан	Явц өдрөөр
Хэргийг системд оруулан хуваарилж, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар тогтооно.	Ахлах референт	1
Хэрэг хуваарилагдсан шүүгчид хэргийг хүлээлгэн өгнө.	Ахлах референт	
Хэрэгтэй урьдчилан танилцаж, хэргийн хувьд хариу өгч шийдвэрлэвэл зохих асуудлын жагсаалтыг тодорхойлно. Бүрэлдэхүүний бусад шүүгчдээс санал авна.	Илтгэгч шүүгч	2-4
Хэргийн чек лист, төсөл, “Хяналтын журмаар хэлэлцэх асуудлын жагсаалт”-ын төслийг тус тус бэлтгэнэ.	Илтгэгч шүүгчийн туслах	5
Шүүх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүний бусад шүүгчдэд хэргийг танилцуулна.	Илтгэгч шүүгчийн туслах	6
Хяналтын журмаар хэлэлцэх асуудлын жагсаалт дахь ажиллагааг гүйцэтгэж танилцуулна.	Судлаач туслах	6-12
Хэрэг хянан шийдвэрлэхэд шаардлагатай судалгааг хийж үр дүнг шүүх бүрэлдэхүүнд ирүүлнэ.	ШССМХ-ийн судлаач	13-23
Шүүх хуралдааны товыг гаргаж, хэргийн оролцогчдод мэдэгдэнэ	Илтгэгч шүүгчийн туслах	23
Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим системд бүртгэнэ.	Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга	30
Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол сонсгосны дараа шийдлийн товчийг цахим хуудаст оруулна.	Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга	30
Шийдвэрийг шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргах бөгөөд хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.		

Хяналтын шатны шүүх хуралдаан

Эрүүгийн хэргийн танхим

153 хэргийг шийдвэрлэсэн байдал




Иргэний хэргийн танхим

244 хэргийг шийдвэрлэсэн байдал



Захиргааны хэргийн танхим

81 хэргийг шийдвэрлэсэн байдал



Бусад шүүх хуралдаан

Хуульд заасан үндэслэлээр давж заалдах журмаар хянан хэлэлцэх шүүх хуралдаанаар

25 хэрэг

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулахаар гаргасан хүсэлт хэлэлцэх хуралдаанаар

48 хэрэг

Сахилгын хэрэг хянан хэлэлцэх шүүх хуралдаанаар

10 хэрэг



Шүүн таслах ажиллагааны хугацаа

Эрүүгийн хэрэг

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцсэн 153 хэргээс нэг хэргийг хянан шийдвэрлэсэн дундаж хугацаа 21 хоног байна.




Иргэний хэрэг

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцсэн 244 хэргээс нэг хэргийг хянан шийдвэрлэсэн дундаж хугацаа 20.2 хоног байна.



Захиргааны хэрэг

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцсэн 81 хэргээс нэг хэргийг хянан шийдвэрлэсэн дундаж хугацаа 25.3 хоног байна.



Сахилгын хэрэг

Улсын дээд шүүхийн хянан шийдвэрлэсэн 10 сахилгын хэргээс нэг хэргийг хянан шийдвэрлэсэн дундаж хугацаа 23.3 хоног байна.



Улсын дээд шүүхийн онцлох шийдвэрүүд

Иргэний хэрэг

Оюун ба УБ төмөр зам, 001/ХТ2023/00019

(Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчөөр тогтоолгох тухай маргаан)
Зориулалтын дагуу ашиглагдах боломжгүй болсон, нурсан барилгыг “үл хөдлөх эд хөрөнгө” гэж үзэхгүй гэж УДШ тайлбарлажээ.

БШӨ ХХК ба Мандах, 001/ХТ2023/00206 (гэм хорын маргаан)

Ажилтан жолоочийн үйл ажиллагаанаас хамаарахгүй шалтгаанаар тээврийн хэрэгслийн эд анги бүрэн бус байсны улмаас зам тээврийн осол гарсан бол ослын улмаас бусдад учирсан хохирлыг тухайн тээврийн хэрэгслийг эзэмшигч-ажил олгогч арилгах үүрэгтэй гэж УДШ үзжээ.

Шийрэв ба Компакт ХХК, 001/ХТ2023/00228

(ажилгүйдлийн тэтгэмжийн маргаан)
Компани нийгмийн даатгалын шимтгэлийг ажилтнаас суутган авсан атлаа нийгмийн даатгалын байгууллагад төлөөгүйн улмаас ажилтан ажилгүйдлийн тэтгэмж авч чадаагүй бол буруутай этгээд буюу тухайн компани уг гэм хорыг арилгах үүрэгтэй гэж УДШ шийдвэрлэв.

Цогт ба Эрдэнэс силвер ХХК, 001/ХТ2023/00035

(хөдөлмөрийн маргаан)
Ажил олгогч ажлаас чөлөөлөх тухай мэдэгдлийг бичгээр баталгаажуулаагүй нь ажилтныг ажлаас чөлөөлөх талаар бодит байдалд өөр бусад байдлаар мэдэгдсэн үйл баримтыг үгүйсгэхгүй гэж УДШ дүгнэжээ.

Эрүүгийн хэрэг

Б-д холбогдох, 84, (хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг)

Байгаль орчинд хохирол учруулсан гэм буруутай этгээдээр тухайн ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээнээс гадна түүнийг нөхөн сэргээж, хамгаалахтай холбоотой гарах зардал буюу хор уршгийг давхар нөхөн төлүүлэх агуулгатай гэж УДШ тайлбарлав.

М-д холбогдох, 49, (хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг)

Ойн модыг зохих зөвшөөрөлгүйгээр зөөвөрлөх нь гэмт хэрэг бөгөөд модыг өөр газар үржүүлэх, ургуулах зорилготой байсан нь үүнд мөн хамаарна гэж УДШ шийдвэрлэв.

Захиргааны хэрэг

Оюун ба УБЕГ, 001/ХТ2023/0090, (төрийн албаны маргаан)

Захиргааны байгууллага төрийн албан хаагчийг байгууллага дотроо өөр ажил албан тушаалд шилжүүлэх эрхийг хэрэгжүүлэхдээ төрийн албан хаагчийг ийнхүү шилжүүлэн ажиллуулах зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүссэн тохиолдолд, тухайлбал хүний нөөцийн дутагдлыг зохицуулах, мэдлэг ур чадварыг нь хөгжүүлэх, эсхүл түүнд нь тохирсон ажлыг хийлгэх зэрэг зайлшгүй объектив шалтгаан нөхцлийг үндэслэх үүрэгтэй, харин өөрийн дур зоргоор, хувийн таарамжгүй харилцаа зэрэг субъектив байдлаар хандах ёсгүй гэж УДШ тайлбарлав.

ЭТТ ХХК ба Татварын байгууллага, 001/ХТ2023/0016

(татварын маргаан)
Засгийн газраас баталсан журам нь батлагдсан өдрөөсөө хойш үйлчлэх бөгөөд захиргаа нь иргэн хуулийн этгээдийн “эрх зүйн байдлыг дордуулсан” хууль тогтоомжийг буцааж хэрэглэх ёсгүй. Засгийн газрын тогтоолоор татвар төлөгчийн төлөх төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх байдлаар “татвар ногдох орлогыг тодорхойлох аргачлал” журмыг баталсныг татварын байгууллага тухайн тохиолдолд, журам батлагдахаас өмнөх хугацаанд буцаан хэрэглэж нэхэмжлэгчид татвар ногдуулсан нь буруу гэж УДШ дүгнэв.

Оройн ангийн төгсөгчид ба МХХ, 001/ХТ2023/0040

(хуульчийн шалгалтад орох эрхийн маргаан)
Өмнө нь өөр мэргэжлээр дээд боловсролын бакалавр зэрэгтэй бөгөөд хуулийн их дээд сургуулийн оройн ангид (их дээдийн болон эчнээ) суралцаж “эрх зүйч” мэргэжлээр төгссөн төгсөгчид нь үндсэн ангийн төгсөгчдийн нэгэн адил хуульчийн эрх авах шалгалтад орох эрхтэй гэж УДШ үзэв.

Нийт шүүгчийн хуралдаан, Шүүгчдийн зөвлөгөөн

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны бүрэн эрх

- ▶ Хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох;
- ▶ Улсын дээд шүүхийн танхимын шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд шүүх бүрэлдэхүүнийг томилох;
- ▶ Шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг гаргах;
- ▶ Хууль тогтоомжийн төслийн талаарх саналаа хууль санаачлагчид хүргүүлэх зэрэг 11 асуудал хамаардаг.

Нийт шүүгчийн хуралдаан 14 удаа товлогдож, 76 асуудлыг хэлэлцсэн.

Тайлбар 9

Улс төрийн
намын
өргөдөл 17

Хуулийн
төсөлд өгсөн
санал 11

Бусад 39

Шүүгчдийн зөвлөгөөн

Шүүгчдийн зөвлөгөөн Улсын дээд шүүхийн бүх шүүгчээс бүрдэх ба хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхээс бусад асуудлаар буюу шүүхийн дотоод ажлын зохион байгуулалт, журмыг тогтоох, шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох зэрэг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэдэг.

2023 онд Улсын дээд шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөн 7 удаа товлогдож 13 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.






14



Жилийн тайлан
2023

Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдаанаас 2023 онд хуулийг зөв хэрэглэх талаар дараах 9 албан ёсны тайлбарыг гаргажээ. Үүнд:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4 дүгээр зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай;	
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 91, 92 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай;	
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар;	
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван зургаадугаар бүлгийн зарим зүйл, хэсэг (§16.3, §16.5)-ийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар;	
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38, 120, 124, 166, 167 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай;	
Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай;	
Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.8, 36.9 дэх хэсгийг тайлбарлах тухай;	
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тайлбарлах тухай;	
Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай.	

Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдаанаас дараах 11 хуулийн төсөлд санал өгсөн. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл;
- Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл;
- Улсын тэмдэгийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн урьдчилсан төсөл.

Олон улсын хамтын ажиллагаа

Канад Улсын шүүхэд

Улсын дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн зарим гишүүд 2022 оны 10 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд Канад улсын шүүхийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлав. Канад улсын Засгийн газрын санхүүжилтээр Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагаас (ОУХЭЗБ) хэрэгжүүлж буй “Монгол Улсад жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх” төслийн хүрээнд шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүд Онтарио муж дахь Гэр бүл, насанд хүрээгүй хүний дагнасан шүүх, Гэр бүлийн хүчирхийллийн хэргийн нэгдсэн шүүх, Онтарио мужийн Дээд шүүх болон Ерөнхий прокурорын яамны Хүүхдэд өмгөөлөл үзүүлэх хэлтсийн үйл ажиллагаатай танилцлаа.



Мөн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид эрх зүйн туслалцаа үзүүлдэг төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй уулзаж, жендерт суурилсан хүчирхийлэл, тэр дундаа гэр бүлийн хүчирхийллийг бууруулах чиглэлээр хэрхэн ажилладаг талаар туршлага судалсан юм.

Ерөнхий шүүгч Олон Улсын Эрүүгийн шүүхэд

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг тэргүүтэй төлөөлөгчид Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ерөнхийлөгч П.Хофманскийн урилгаар Нидерланд улсын Гаг хотноо Ромын дүрэмд оролцогч талуудын Шүүгч нарын семинар, Шүүхийн жилийн нээлтийн үйл ажиллагаанд оролцлоо. Ерөнхий шүүгч тэргүүтэй төлөөлөгчид Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ерөнхийлөгч П.Хофмански, Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ерөнхий прокурор Карим Кан, НҮБ-ын Олон Улсын шүүхийн Ерөнхийлөгч Жоан Донахью нартай тус тус уулзаж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, тэдний зүгээс хэрэгжүүлж буй сургалт, дадлагажуулах хөтөлбөр зэрэгт Монгол Улсын шүүхийн ажилтнуудыг хамруулах боломжийн талаар санал солилцон, харилцан идэвхтэй ажиллахаар тохиролцсон байна. Ерөнхий шүүгч Д.Ганзориг манай улс Олон Улсын Эрүүгийн шүүхийг байгуулах үйлсэд идэвхийлэн оролцсон анхны гишүүн орнуудын нэг болохыг онцлоод шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсад хэрэгжүүлж байгаа эрх зүйн шинэчлэлийн талаар танилцуулсан байна.



Монгол Улсын дээд шүүхийн шүүгч Д.Эрдэнэбалсүрэн Олон Улсын эрүүгийн шүүхэд томилогдон ажиллахаар болов

2023 оны 12 дугаар сарын 4-14-ний өдрүүдэд Нью-Йорк хотноо хуралдсан Олон улсын эрүүгийн шүүх (ОУЭШ)-ийн Ромын дүрэмд оролцогч талуудын Ассамблейн 22 дугаар чуулганы үеэр нийт гишүүн орны олонхын саналаар Монгол Улсын дээд шүүхийн шүүгч Дамдины Эрдэнэбалсүрэн ОУЭШ-ийн шүүгчээр сонгогдов. Тус сонгууль нь 11 тойрог явагдаж, 13 улс 6 суудлын төлөө өрсөлдсөн бөгөөд шүүгч Д.Эрдэнэбалсүрэн авбал зохих босго 76 саналаас хамгийн их буюу (+5) санал авч эхний тойрогт 81 саналаар шууд сонгогдсон юм.



Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2023 оны нэгдүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаас Д.Эрдэнэбалсүрэнг Олон улсын эрүүгийн шүүхийн шүүгчид нэр дэвшүүлж, бүхий л хугацаанд дэмжин ажилласан байна.

Олон улсын эрүүгийн шүүх нь төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны болон түрэмгийллийн гэмт хэрэг үйлдсэн хувь хүмүүсийг шүүх үүрэг, зориулалттай байнгын ажиллагаатай шүүх байгууллага юм. Тус шүүхэд Монгол Улсын шүүгч анх удаа сонгогдож ОУЭШ-ийн Ромын дүрмийн Оролцогч талууд болох 123 улсад энх тайван, шударга ёсыг тогтооход хувь нэмрээ оруулан ажиллахаар боллоо.





Канадын шүүхийн Ерөнхий шүүгчдийг хүлээн авч уулзав /2023-02-03/




Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол Улсад суух Элчин сайдыг хүлээн авч уулзав /2023-04-05/



Улсын дээд шүүхэд Европын холбооны зөвлөхүүд ажиллалаа /2023-03-19/



БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдыг хүлээн авч уулзлаа /2023-06-30/



БНТУ-ын Хууль зүйн дэд сайд, Улсын дээд шүүхийн шүүгч тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав /2023-10-05/



Ханнс-Зайделийн сангийн Ерөнхий Нарийн бичгийн даргыг хүлээн авч уулзав /2023-09-13/



Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Ц.Цогт нар БНСУ-д болсон ОУ-ын эрүүгийн шүүхийн Ази Номхон далайн бүсийн уулзалтад оролцов. /2023.11.13-16/



Улсын дээд шүүхийн шүүгчид БНСУ-ын шүүхийн сургалт, судалгааны хүрээлэнгийн урилгаар Шүүх чадавхийг бэхжүүлэх сургалтад оролцож, тус улсын шүүхийн цахимжилттай танилцав. /2023.04.23-29/

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүгчид ХБНГУ-ын Ханнс Зайделийн сангийн урилгаар тус улсын захиргааны хэргийн дээд шүүхийн шүүгч нартай мэргэжлийн уулзалт хийж санал солилцов /2023.05.18-28/



НЭЭЛТТЭЙ ШҮҮХ

Уулзалт, хэлэлцүүлэг, сургалт

Шүүхэд итгэх олон нийтийн итгэл ба шүүгч /2023-03-22/



Баривчлах, цагдан хорих ажиллагаанд хүний эрхийг хангах чиглэлээр санал хүргүүлэв /2023-04-25/



Шүүхийг цахимжуулах талаар зөвлөлдөв /2023-03-23/



“Шүүхийн сэтгүүл зүйн мэргэшүүлэх хөтөлбөр” сургалт боллоо /2023-09-22/



Шүүхийн цахимжуулалтыг сайжруулах, хиймэл оюун ухааныг ашиглах талаар хэлэлцэв /2023-03-24/



“Шүүхийн практик судлал” хэлэлцүүлэг боллоо /2023-12-08/



Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид Улсын дээд шүүхэд

Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах, сурагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, мэргэжил сонголтод дэмжлэг үзүүлэх зорилгоор Улсын дээд шүүхийн чиг үүрэг, үйл ажиллагаатай сурагчдыг танилцуулах хөтөлбөрийг 2023 онд эхлүүлээ.



Ерөнхий боловсролын “Шинэ эхлэл” сургуулийн 22 сурагч 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Улсын дээд шүүхэд зочилж, шүүгч, ажилтнууд ажлаа танилцуулан холбогдох асуултад хариулав.



Нийслэлийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 11 дүгээр ангийн сурагчид Монгол Улсын дээд шүүхийн үйл ажиллагаатай 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр танилцлаа.



Хуульчдад зориулсан сургалт

Улсын дээд шүүхийн шүүгч Ч.Хосбаяр, Г.Банзрагч, Н.Баярмаа нар бусад хуульчидтай хамтран Үндсэн лекц-цахим хичээл бэлтгэв.




Улсын дээд шүүхийн шүүгч Б.Амарбаясгалан, Х.Батсүрэн, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Баярмаа, П.Золзаяа, Ц.Цогт, П.Соёл-Эрдэнэ нар хуульчийн шалгалтын гарын авлага зохиох, редакторлах, хичээл заах, шалгалт зохион байгуулах ажилд оролцов.




Номын сан Шүүгчдийн бүтээл

Номын фондыг баяжуулах, эргэлтийг сайжруулах зорилгоор Монгол Улсын дээд шүүхийн шүүгчид болон бүтцийн нэгжүүдээс 32 нэр төрлийн 306 ном, хэвлэлийн захиалгыг авч, тайлангийн хугацаанд 39 нэр төрлийн 197 ном, гарын авлага худалдан авч номын сангийн фондоо баяжуулсан.

Номын санд цахим хайлтын Коха системийг нэвтрүүлж, номын фонд дахь 6272 номыг цахим каталогид хөрвүүлэн хэрэглээнд нэвтрүүлсэн байна. Номын фондын баяжилтыг үе шаттайгаар хэрэгжүүлж, электрон каталогтой болгосон.



2023 онд Улсын дээд шүүхийн шүүгчдийн гаргасан бүтээл



“Монгол Улс дахь хуулийн тайлбар: Абстракт аргачлалаас чөлөөлөгдөх нь” сэдэвт бүтээл. Шүүгч Ц.Цогт



“Монгол Улсын үл хөдлөх хөрөнгийн эрх зүйн хөгжил: Суурь зарчмыг нэгтгэх нь” сэдэвт бүтээл. Шүүгч Н.Баярмаа



Захиргааны процессын эрх зүй сурах бичгийн 2 дахь хэвлэлт. Шүүгч Г.Банзрагч



Нийт шүүгчийн чуулган 2023

Бүх шатны шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн Нийт шүүгчийн чуулганыг хоёр жил тутам зохион байгуулахаар хуульд заасны дагуу ээлжит хоёрдугаар чуулган 2023 оны 9 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулагдав.

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг шүүгчдэд хандаж шүүх эрх мэдлийн өнөөгийн байдал, дараагийн III чуулган хүртэлх хугацаанд үр дүн гаргавал зохих зарим асуудлыг хөндөн үг хэлэв.

Шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т зааснаар Нийт шүүгчийн чуулган нь Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны тайланг сонсох, хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналыг Улсын дээд шүүхэд уламжлах, хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилж нийтлэг журмыг батлах, шүүхийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг хэлэлцсэн байна. Нийт шүүгчийн чуулганы дэгд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэж батлав.

Санамсаргүй аргаар хэрэг хуваарилах процессыг сайжруулах, давж заалдах шатнаас буцсан хэргийг хуваарилах болон бүрэлдэхүүний шүүгчийг санамсаргүй аргаар сонгоход программ ашиглах асуудлыг хэлэлцэж, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоол батлав.

Чуулганыг зохион байгуулах ажлын хэсгийг Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүгч М.Батсуурь ахалж, чуулганыг тус танхимын шүүгч Д.Батбаатар даргалж ажиллав. Энэ удаагийн чуулганд бүх шатны шүүхийн 438 шүүгч оролцжээ.





“Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуварилгах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэв.



Канад улсын Нью Брансвик мужийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Марк Ричард хэлэлцүүлэгт зочноор оролцож өөрийн улсын шүүхийн сайн туршлагаас хуваалцав.



Шүүгчид хориглох зүйл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх Шүүхийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг хэрхэн ойлгож, хэрэглэх талаар Улсын дээд шүүхэд санал хүргүүлэхээр тогтсон байна.



Улсын дээд шүүхийн Тамгын газар

Эрхэм таны энэ өдрийн амар амгаланг эрж, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын чиг үүрэг, 2023 онд хэрэгжүүлсэн ажлын талаар товч мэдээллийг хүргэе.

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар хуульд зааснаар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

2023 онд Улсын дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, хуулийн төсөлд санал өгөх бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд шаардагдах 87 судалгааг Тамгын газраас гүйцэтгэв. Мөн батлагдсан албан ёсны 16 тайлбарыг эмхэтгэн шүүгч, хуульчдын гар дээр хүргэхэд бэлэн болгож, шүүхийн практик судалгааны багц заавар, аргачлалыг боловсруулан мөрдөж эхлээд байна.

Шүүхийн практик судлал хууль зүйн шинжлэх ухаанд харьцангуй бие даасан судлагдахуун болохыг тодорхойлж, цаашид тухайлсан судалгааг хөгжүүлэхийн тулд “Шүүхийн практик судлал-2023” хэлэлцүүлгийг бүх шатны шүүхийн төлөөллийг оролцуулан танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгууллаа.

Шүүхийн тухай хуульд зааснаар олон нийтийн анхаарал татсан, эрх зүйн танин мэдэхүйн ач холбогдолтой, тайлбарлан танилцуулбал зохих шийдвэрүүдийн тоймыг эмхэтгэн хэвлүүлж, цахим хуудаснаа нээлттэй байршуулаад байна. Энэ ажлыг бүх шүүхийн хэмжээнд орон даяар хэвшүүлэх сургалт, сурталчилгаа, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг Улсын дээд шүүхээс удирдан зохион байгуулж ажилласан.

Шүүгчийг ном, гарын авлагаар хангах чиг үүргийн хүрээнд Улсын дээд шүүхийн номын санг хууль зүйн шинжлэх ухааны сүүлийн үеийн гадаад, дотоодын ном, бүтээлээр баяжуулан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цахим сангуудад хандах боломжийг бүрдүүлэв. Мөн Улсын дээд шүүхийн 1996-2022 онд хамаарах 1487 хадгаламжийн нэгж бүхий архивын сан хөмрөгийг цахимжууллаа.

Иргэд цаг хугацаа, орон зайн хязгаарлалтаас үл хамааран шүүхийн үйлчилгээг хялбар, дөхөм аргаар авах, шүүх хуралдааныг цаг алдалгүй товлон зохион байгуулах, төрийн байгууллага хооронд мэдээлэл шуурхай солилцох, шүүхийн мэдээ, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгын хүрээнд “Шүүхийн цахимжуулалтын төсөл”-ийг боловсруулж, Шүүхийн ерөнхий зөвлөлд танилцуулан хүлээлгэж өгөв.

2023 онд бид Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо зэрэг байгууллагуудтай хамтран Европын холбооны “Твиннинг”, “Таэикс” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх эхлэлийг тавьж, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнтэй хамтран

Дэлхийн оюуны өмчийн байгууллага, Бүгд Найрамдах Турк Улсын Шүүхийн академи, Бүгд Найрамдах Сингапур Улсын Шүүхийн коллеж зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагааг шинээр тогтоох, гүнзгийрүүлэх ажлыг хэрэгжүүлэв.

Шүүхийн захиргааны албан хаагчдыг чадавхжуулах цогц хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс гадна, иргэд, оюутан, сурагчдын эрх зүй, шүүхийн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой “Шүүхийн боловсрол” хөтөлбөрийг эхлүүлж, олон төрлийн зөвлөгөө, видео хичээл, мэдээлэл, судалгааг бэлтгэн нээлттэй байршуулаад байна. Түүнчлэн шүүхийн иргэн төвт, нээлттэй үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд шүүх хуралдааныг шууд дамжуулах (live stream), видео архив үүсгэж, иргэд хүссэн үедээ хуралдааныг цахимаар нөхөж үзэх боломжийг бүрдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.



Тайлант хугацаанд зайнаас болон биечилсэн хэлбэрээр 5476 иргэн, хуулийн этгээдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой мэдээлэл, лавлагаа өгснөөс гадна, 342 өргөдөл гомдол, 911 албан бичиг хүлээн авч, 3955 албан бичгийг холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж ажиллалаа.

2023 онд гүйцэтгэлийн 1 зорилго, 3 зорилт, 6 дэд зорилтын хүрээнд 58 арга хэмжээ, 24 дэд арга хэмжээ нийт 82 арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд ирэх 4 жилийн стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж, Шүүгчдийн зөвлөгөөнд танилцуулсан. Тус Шүүгчдийн зөвлөгөөнөөс Тамгын газрын бүтэц, орон тоог 2023 онд шинэчлэн батлаад байна.

Бид шүүхийн өрсөлдөх чадварыг олон улсын тавцанд бататгах, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүхийн үйлчилгээг иргэнд ойртуулах, нээлттэй ил тод байдлыг дээшлүүлэх чиглэлд тодорхой зорилт, арга хэмжээнүүдийг төлөвлөн ажиллаж байна.

Та бүхэн Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлантай байгууллагын цахим хуудаснаас танилцах боломжтой.

Тамгын газрын дарга
С.ЗАЯАДЭЛГЭР

Иргэдийн боловсролд




2023 онд Улсын дээд шүүхээс “Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, иргэдийн шүүхийн боловсролыг дээшлүүлэх, шүүхийн тогтолцоо, шүүн таслах ажиллагаа, холбогдох хууль тогтоомжийн талаар үнэн, зөв мэдлэг, мэдээлэл олгох” зорилгоор “Шүүхийн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэллээ.

Хөтөлбөрийн хүрээнд шүүхийн мэдээллийг дуу, дүрс, текст, видео хэлбэрээр бэлтгэн олон нийтэд энгийн ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар тайлбарлан таниулах, шаардлагатай судалгаа шинжилгээ хийх, сургалт зохион байгуулах ажлыг гүйцэтгэж байна.

Улсын дээд шүүхийн www.supremecourt.mn цахим хуудсанд “Таны эрх зүйн боловсролд” цэсийг ажиллуулж 9 анимейшн, 10 түгээмэл асуулт хариулт, 6 судалгааны тойм нийтлэл байршуулан “Шүүх хэвлэлийн хуудаснаа” дэд цэсийг хөгжүүлж эхэллээ.

Тус цахим хуудаснаас Монгол Улсын дээд шүүхийн бүтэц, бүрэн эрх, үйл ажиллагааны журам, хуулийг зөв хэрэглэх талаарх албан ёсны тайлбар, нөлөөллийн мэдүүлэг, шүүхийн ил тод байдал зэрэг мэдээлэлтэй сонирхолтой, ойлгомжтой хэлбэрээр танилцах боломжтой.




Монгол Улсын дээд шүүх

29



ЭХ-ийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргасан тухай



Таны эрх зүйн боловсролд цэс



